



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/145/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2021 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Аудитын менежер: Утас: 7058-4207 Аудитор: Утас: 7000-3775	Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn И.Сэмжидмаа Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Э.Нандинчимэг Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 293

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020263

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,703,425.12	19,355,699.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,703,425.12	19,355,699.00
351	Түүхий эд материал	39,021,904.64	3,482,410.00
35110	Тусгай зориулалттай материал	39,021,904.64	3,482,410.00
354	Хангамжийн материал	35,681,520.48	15,873,289.00
35410	Бичиг хэргийн материал	234,000.00	275,000.00
35420	Аж ахуйн материал	28,648,030.48	12,782,085.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,216,204.00
35470	Бусад хангамжийн материал	6,799,490.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	87,508,046.68	103,994,688.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	87,508,046.68	103,994,688.88
392	Биет хөрөнгө	87,508,046.68	103,994,688.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,000,000.00	5,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,749,999.56)	(2,999,999.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,378,760.00	66,509,090.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,759,820.99)	(39,974,999.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,999,640.00	50,026,660.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,170,514.39)	(27,200,615.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,764,530.00	6,349,830.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,204,548.30)	(2,003,913.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,900,000.00	56,763,636.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,650,000.08)	(8,475,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,800,000.00	22,800,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(22,800,000.00)	(22,800,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	162,211,471.80	123,350,387.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	162,211,471.80	123,350,387.88
51	Засгийн газрын хувь оролцоо	162,211,471.80	123,350,387.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65,759,520.00	65,759,520.00
51101	Өмч - төрийн	65,759,520.00	65,759,520.00
512	Хуримтлагдсан үр дүн	96,344,987.80	57,550,203.88
51210	Өмнөх үеийн үр дүн	96,344,987.80	96,411,287.80
51220	Тайланг үеийн үр дүн	-	(38,861,083.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	106,964.00	40,664.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	162,211,471.80	123,350,387.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	684,062,829.00	613,164,306.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,398,000.00	24,533,636.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,398,000.00	24,533,636.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,398,000.00	23,633,636.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,398,000.00	770,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	22,863,636.00
120009	Бусад орлого	-	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	682,664,829.00	588,630,670.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	256,315,229.00	137,370,870.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,714,720.00	4,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ,хөрөнгө,гүүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	238,600,509.00	129,370,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	426,349,600.00	451,259,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	426,349,600.00	451,259,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	695,425,026.62	651,485,494.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,425,026.62	651,485,494.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,611,917.62	605,673,921.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,434,797.00	335,360,688.01
210101	Үндсэн цалин	292,589,297.00	302,958,811.52
210102	Нэмэгдэл	1,000,000.00	22,101,376.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,845,500.00	10,300,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,718,570.00	42,971,915.00
210201	Тэтгэврийн даатгал	24,482,733.00	29,555,793.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,209,283.00	3,265,338.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,961,325.00	1,871,867.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,108.00	1,570,843.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,039,121.00	6,708,074.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,075,707.00	2,801,851.00
210301	Гэрэл, цахилгаан	69,801.00	-
210302	Түлш, халаалт	3,005,906.00	2,801,851.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,012,991.00	70,100,092.12
210401	Бичиг хэрэг	1,333,100.00	1,356,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,740,000.00	10,484,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	939,891.00	909,477.00
210408	Бараа материал акталсны зардал	-	57,349,915.12
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,628,000.00	7,739,296.00
210601	Багаж, техник хэрэгсэл	83,000.00	-
210602	Тавилга	-	30,000.00
210604	Урсгал засвар	1,545,000.00	7,709,296.00
2107	Томилголт, зочны зардал	6,347,700.00	2,390,200.00
210702	Дотоод албан томилголт	6,347,700.00	2,390,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,000.00	690,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оноцлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	268,334,152.62	143,619,879.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	247,346,565.00	125,312,781.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	20,987,587.62	18,307,098.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,813,109.00	45,811,572.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,311,900.00	1,907,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,370,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,941,000.00	1,907,200.00
2133	Удсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,501,209.00	43,904,372.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,501,209.00	43,904,372.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,362,197.62)	(38,321,188.92)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	539,895.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	539,895.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(539,895.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11,362,197.62)	(38,861,083.92)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	683,673,189.00	590,300,670.00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	1,398,000.00	1,670,000.00
120	Нийтлэг татварын бүс орлого	1,398,000.00	1,670,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,398,000.00	770,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,398,000.00	770,000.00
120009	Бусад орлого	-	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	682,275,189.00	588,630,670.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	255,925,589.00	137,370,870.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,714,720.00	4,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс гухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	238,210,869.00	129,370,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	426,349,600.00	451,259,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	426,349,600.00	451,259,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	683,673,189.00	590,300,670.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	683,673,189.00	590,300,670.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,860,080.00	544,489,097.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,434,797.00	335,360,688.01
210101	Үндсэн цалин	292,589,297.00	295,809,635.52
210102	Нэмэгдэл	1,000,000.00	29,259,552.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,845,500.00	10,300,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,718,570.00	42,971,915.00
210201	Тэтгэврийн даатгал	26,764,219.00	29,555,793.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,994,494.00	3,354,035.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,844,200.00	1,783,170.00
210204	Ажилгүйдлийн даатгал	866,318.00	1,482,147.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,249,339.00	6,796,770.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,075,707.00	2,801,851.00
210301	Гэрэл, цахилгаан	69,801.00	-
210302	Түлш, халаалт	3,005,906.00	2,801,851.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,933,391.00	12,791,177.00
210401	Бичиг хэрэг	1,253,500.00	1,397,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,740,000.00	10,484,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	939,891.00	909,477.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	5,449,985.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	5,449,985.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,582,990.00	22,425,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,582,990.00	10,083,500.00
210602	Тавилга	-	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	9,842,000.00
2107	Томилголт, зочны зардал	6,347,700.00	2,390,200.00
210702	Дотоод албан томилолт	6,347,700.00	2,390,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,000.00	690,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	253,206,925.00	119,607,781.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	253,206,925.00	119,607,781.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,813,109.00	45,811,572.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,311,900.00	1,907,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,370,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,941,000.00	1,907,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,501,209.00	43,904,372.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,501,209.00	43,904,372.99
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,759,520.00	106,964.00	96,344,987.80	00.00	162,211,471.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	66,300.00	00.00	66,300.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,759,520.00	106,964.00	96,411,287.80	00.00	162,277,771.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-66,300.00	00.00	00.00	-66,300.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-38,861,083.92	00.00	-38,861,083.92
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,759,520.00	40,664.00	57,550,203.88	00.00	123,350,387.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	452,259,800.00	452,029,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,259,800.00	452,029,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,259,800.00	424,881,316.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,467,600.00	335,360,688.01
210101	Үндсэн цалин	302,241,600.00	295,800,635.52
210102	Нэмэгдэл	32,626,000.00	29,259,552.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	10,300,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,589,500.00	42,971,915.00
210201	Тэтгэврийн даатгал	32,763,500.00	29,555,793.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,206,500.00	3,354,035.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,564,100.00	1,783,170.00
210204	Ажилгүйдлийн даатгал	641,300.00	1,482,147.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,414,100.00	6,796,770.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,854,600.00	2,801,851.00
210301	Гэрэл, цахилгаан	1,306,800.00	-
210302	Түлш, халаалт	3,547,800.00	2,801,851.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,245,900.00	12,791,177.00
210401	Бичиг хэрэг	1,753,500.00	1,397,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,488,000.00	10,484,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,400.00	909,477.00
2105	Нормативт зардал	5,500,900.00	5,449,985.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,500,900.00	5,449,985.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,583,500.00	22,425,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,083,500.00	10,083,500.00
210602	Тавилга	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,842,000.00
2107	Томилголт, зочны зардал	3,557,800.00	2,390,200.00
210702	Дотоод албан томилголт	3,557,800.00	2,390,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,460,000.00	690,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,300,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	330,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	1,907,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,907,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,907,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	452,259,800.00	452,029,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	451,259,800.00	451,259,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	451,259,800.00	451,259,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	770,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	770,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	33.00	33.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,270,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,270,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,607,781.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,607,781.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,607,781.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,663,089.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	18,663,089.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,270,870.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,270,870.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгэдээс авсан хандив, тусламж	4,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,370,870.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	900,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг А.Гантулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулсан гэрээ, мөн Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 652,025.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 13,040.5 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,861.1 мянган төгрөгөөр буюу 24 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	74,703.4	19,355.6	-55,347.7
Үндсэн хөрөнгө	234,843.0	207,449.2	-27,393.8
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(147,335.0)	(103,454.5)	(43,880.5)
Нийт хөрөнгө	162,211.4	123,350.3	-38,861.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	65,759.5	65,759.5	65.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	162,211.4	123,350.3	-38,861.0

Бараа материал дансны үлдэгдэл 19,355.6 мянган төгрөг болж 55,347.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,449.2 мянган төгрөг болж 27,393.8 мянган төгрөгөөр буурсан нь ИТХ-ын тогтоолын дагуу 39,183.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 23,544.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, 12,470.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 123,350.3 мянган төгрөг болж 38,861.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 70,898.5 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 43,939.5 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 452,259.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 452,259.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 452,259.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 451,259.8 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 1,000.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 451,259.8 мянган төгрөг санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагаанаас 770.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 426,788.5 мянган төгрөгийг зарцуулж 25,741.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 426,788.5 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байна. Үүнээс цалин,нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 378,332.6 мянган төгрөг буюу нийт зардлын 88.6 хувийг эзэлж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 129,370.8 мянган төгрөг, Засаг даргын нөөц сангаас 4,000.0 мянган төгрөг, хандив тусламжаар 4,000.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 900.0 мянган төгрөгийн нийт 138,270.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлж, 18,663.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 119,607.8 мянган төгрөгийг мод тарих нээлтийн арга хэмжээний зардал, биотехникийн арга хэмжээний зардал, томилолт, тандалт судалгаа хийх зардалд зарцуулсан.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 129 мэдээллийг хугацаандаа оруулж, 14 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Төсвийн байгууллагын батлагдсан төсвийн 449,318.5 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны Санхүүгийн тайлангийн зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь биелүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 177,275.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 177,275.3 мянган төгрөгийн зөрчилд 606.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 153,868.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 22,800.0 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 177,275.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 177,275.3 мянган төгрөгийн зөрчилд 606.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 153,868.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 500.9 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Томилолтын зардалд 106.0 мянган төгрөгөөр илүү тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

3. Ажилчдын нөхөн олгосон цалинтай холбоотойгоор үүссэн НДШ-ийн илүү төлөлт 2,257.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэж санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ ... 4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 4.3-т бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант оны эцэст 132,432.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант хугацаанд гарсан зардлаас 19,179.0 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 22.800.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 22,800.0 мянган төгрөгийн 2013.12.31-нд ашиглалтад орсон, 5 жилийн ашиглалтын хугацаатай элэгдлээрээ өртгөө нөхсөн ашигладаггүй ArcGIS10.0.1 программ бүртгэлтэй байна.

1.2. *Эрсдэл:*

Монгол Улсын Ерөнхий аудиторын чиглэлийн дагуу нэгдсэн журмаар тогтоосон эрсдэл.

1.3. *Өгсөн зөвлөмж:*

Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг данснаас хасах саналтай байна.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хэрэгжүүлж ажиллана



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ДОА-2021/145/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөрөнгийн тооллогын баримт байхгүй Жагсаалт гаргаад дээр нь тэмдэглээ хийсэн баримт авчирч өгсөн /113,076.4 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого байхгүй/ Бараа материал дахь хөрөнгийн тооллогын баримт хангалтгүй жагсаалт гаргаад нярав нь гарын үсэг зурсан баримт ирүүлсэн. Тооллого хийх тушаал баримтад байхгүй. Тооллогын тушаал гаргаагүй. 19,355.6 мянган төгрөгийн хөрөнгө тоолсон баримт байхгүй.	132,432.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн
2	Нийт 129 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 14 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна. Үүнд: Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр) Санхүүгийн тайлан (Хагас жилээр) Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр) Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) Нийтийн албанд нийтийн		Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн

	болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) зэрэг мэдээллүүдийг 5 болон 12 дугаар сард хоцорч мэдээлсэн бөгөөд мэдээний мөнгөн дүн 449,318.5 мянган төгрөг байна.				
3	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл 22,800.0 мянган төгрөгийн өртөгтэй 2013.12.31-нд ашиглалтад орсон 5 жилийн ашиглалтын хугацаатай, элэгдлээрээ өртгөө нөхсөн одоо ашигладаггүй ArcGIS10.0.1 программ бүртгэлд байна.	22,800.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн
4	Тус байгууллагаас өөр харьяаны байгууллагад шилжин ажилласан боловч тухайн ажилтнуудад 1-7 сарын хугацаанд цалин олгогдоогүйг шүүхээр шийдвэрлүүлэн цалинг нөхөн олгосон байна. 2 ажилтны 1-7 сарын цалингийн НДШ-ийг тайланд засвар оруулахаар НД байгууллагад хүсэлт гаргасан боловч хугацаа хойшилсоор он дамжсан байна. 2020 оны 12 сард цалинг нөхөн олгохдоо 2,257.4 мянган төгрөгийн шимтгэлийг НД руу төлсөн боловч санхүүгийн тайлан дээр авлага өр төлбөрөөр тусгаагүй тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	2,257.4	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн
5	Томилолтын зардлыг холбогдох анхан шатны баримттай тулгахад 2020.04.28-ны өдөр олгосон 724.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг 106.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	106.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн
6	Дорнод бүсийн эрчим хүчний систем 38.3 мянган төгрөг, МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО 11.0 мянган төгрөг, НИК 10,314.4 мянган төгрөг, Номин тав трейд 150.0 мянган төгрөг, Шилэн ХХК 2,000.0 мянган төгрөг, Мянган ургац ХХК 700.0 мянган төгрөг, Жорон ХХК 5,965.3 мянган төгрөг зэрэг нийт 19,179.0 мянган төгрөгийн баримт цахим төлбөрийн системд шивэгдээгүй байна.	19,179.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн



7	Батлагдсан төсөв 10488.0 мянган төгрөг ба нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлогоо 13,019.4 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг хийсэн байна. Шатахууны зарцуулалтын ЗТХС-ын баталсан 2019 оны 390 тушаалаар Жишиг нормыг тооцоолоход 500.9 мянган төгрөгийн илүү зарцуулалтыг хийсэн байна.	500.9	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	А.Гантулга З.Дарьсүрэн
ДҮН		177,275.3			